

## МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ШИЛЖИЛТ

Д.Чимэддагва

Аливаа улс орны эдийн засаг нийгмийг бүхэлд нь авч үзвэл эрэлт, нийлүүлэлт гэсэн эсрэг тэсрэг харилцан уялдаа бүхий нэгдмэл системээс бүрддэг билээ. Дэлхийн эдийн засаг даярчлагдахын хирээр улс орнуудын бие биенээсээ хамаарах хамаарал улам хүчтэй болж, ялангуяа банк санхүү, үндэстэн дамнасан корпорацуудын үйл ажиллагаа улам бүр өргөжиж байна. Шинжлэх ухаан технологийн дэвшил, үйлдвэрлэлийн үр ашгийн дээшлэлт, улс төрийн хамтын ажиллагаа нь дэлхий дахиныг улам бүр ойртуулан нягтруулж байна. Гэсэн хэдий ч энэ бүх үр шимийг дэлхийн олон зуун сая ядуучууд хүртэхгүй байгаа бөгөөд даярчлал нь алан хядлага, зэвсэгт мөргөлдөөн, байгаль орчны бохирдол болон ДОХ гэх мэт шинэ хэлбэрийн олон улсын тулгамдсан асуудлыг дэгдээж байгаа тул шүүмжлэлд өртсөөр байна. Нөгөө талаас дэлхийн эдийн засгийн хөдөлмөрийн хувиар өөрчилөгдөж хөгжилтэй орнууд мэдлэг шингэсэн бүтээгдэгдэхүүн ( программ хангамж, онгоц, электрон техник г.м) үйлдвэрлэж, тэдгээр орнуудын өргөн хэрэглээний бараа, түүхий эдийг хөгжиж буй орнууд хангах хандлагатай болжээ.

Дэлхийн улс орнууд энэхүү нөхцөл байдлыг харгалзан 2000 оны 9 сард зохион байгуулагдсан Нэгдсэн Үндэстний Байгууллагын Мянганы дээд хэжээний цуглаанаас баталсан Мянганы Хөгжлийн Тунхаглалд МХТ нэгдэн ядуурлыг бууруулах үйлст уриалсан билээ.

Дотоод хуримтлал хязгаарлагдмал, хөрөнгө оруулалтын нилээд хэсгийг гадаадын зээл тусламжаар нөхдөг Монгол орны хувьд даярчлалын нөхцөлд өөрийн орон зайгаа олж хэрхэн хөгжих вэ гэдэг нь бид бүхний анхаарал хандуулах асуудал билээ.

Улс орон бүр өөрийн уламжлал, зан заншил, түүх, байгал цаг уур, эдийн засгийн суурь орчин гээд олон хүчин зүйлээр ялгаатай боловч дэлхийн улс орнуудын хөгжлийн хандлага, туршлагыг харгалзан үзэхгүйгээр тухайн улс хөгжлийн стратегийг тодорхойлоход хүндрэлтэй нь ойлгомжтой.

Улс төр эдийн засгийн Ухааны эцэг хэмээгдэх Адам Смит 1776 онд бичсэн “Үндэсний баялаг” номондоо сонгодог эдийн засгийн гол суурийг тавьсан. Энэхүү бүтээлд Үнийн тухай сургааль нилээд зонхилох байр суурийг эзэлдэг бөгөөд эрэлт нийлүүлэлтийн харьцаанд бараа бүтээгдэхүүний үнэ чухал байр суурьтайг тодорхойлсон.

1960 оны сүүлээр Макро эдийн засгийн онолын үзэл баримтлалд нэг талаас Милтан Фредманы, нөгөө талаас Кеунесийн онолын дэмжигч нар тухайлбал Франциско Модиглани, Жемис Тобин байсан бол 1970 оноос шинэ сонгодог эдийн засагчдын мөнгөний үзэл баримтлал нилээд хүчээ авч эхэлсэн. Мөн Кеунесийн үзлийг баримтлагч гурав дахь үеийн эдийн засагчид ч гарч ирсэн. Тухайлбал Грег Манкив, Лари Суммарс, Жорж Акерлоф г.м

Шинэ сонгодог эдийн засагч нар өрх гэр, фирмүүд өөрийн үйл ажиллагаагаа явуулахдаа гаргаж буй шийдвэр нь зах зээлийн хөгжлийн шийдвэрлэгч хүчин зүйл ба цалин болон үнэ нь эрэлт, нийлүүлэлтийг зохицуулдаг хэмээн үздэг. Кеунесийн шинэ эдийн засагчид зах зээл нь хувийн эрх сонирхол чухал боловч энэ нь зарим үед тийм ч төгс бус хэмээн үздэг.

Хуучин социалист гэгдэх төрийн өмч давамгайлсан эдийн засагтай орнуудын зах зээлийн эдийн засагт шилжих явц нь үндсэн 2 загвар дээр суурилж байна. Нэгдүгээрт, ОУВС, Дэлхийн Банкны хүлээн зөвшөөрсөн хөгжиж буй орнуудын шинэчлэлтийг бүтцийн өөрчлөлттэй хослуулах үзэл баримтлал ба макро эдийн засгийн тогтворжилт дээр үндэслэсэн Зүүн Европийн орнуудын загвар ордог. Энэ нь хэрэв макро эдийн засаг

тогтвортой байвал эдийн засаг хөгжинө гэсэн үзэл дээр суурилдаг. Үүнийг голлон үнийн тогтвортой байдлаар тайлбарладаг. Өөрөөр хэлбэл шилжилтийн эдийн засагт инфляцийн асуудал нэлээн чухал байдаг. Хоёрдугаар буюу Азийн загвар гэдэг нь микро эдийн засгийн өөрчлөлт дээр суурилах ба төсвийн бүтэц, өмчийн харилцаа, банкны тогтолцоон дээр төвлөрдөг.

Япон болон Өмнөд Азийн орнуудын хөгжлийн загвар нь судлаачдын анхаарлыг нилээд татдаг. 1960-1990 онуудад Зүүн өмнөд Азийн 33 орон бусад бүс нутгийн орнуудаас эдийн засгийн өсөлт нь илүү хурдацтай нэмэгдсэн. Эдгээр орнуудаас Япон болон Конг-Конг, Өмнөд солонгос, Сингапур, Тайван мөн шинээр үйлдвэржиж буй Индонези, Тайланд зэрэг орнуудын хөгжлийн туршлага нилээд сонирхолтой. Японы эдийн засгийн хөгжлийн хурдац 1960 оноос эхэлж хүчээ авсан бөгөөд нилээд өвөрмөц түүхэн замналтай.

1980 оноос Зүүн өмнөд Азийн зарим орнуудын эдийн засгийн өсөлтийн хурдац эрс нэмэгдсэн. Эдгээр орнууд байгалийн нөөц хомстой, хүн амын нягтшил маш өндөртэй зэргээрээ ойролцоо боловч ялгаатай талууд бас л байсан. Конг-Конгоос бусад орнуудын хувьд үйлдвэрлэлийн хөгжилд Засгийн газрын оролцоо нилээд өндөр байжээ. Мөн үйлдвэрлэлийн бүтцийн хувьд Өмнөд Солонгост том корпорацууд, Тайванд жижиг дунд үйлдвэрүүд давамгайлан хөгжиж иржээ.

Эдгээр орнуудын үйлдвэрлэлийн бодлого амжилтанд хүрсэний нэг гол хүчин зүйл нь маш сайн улс төр, эдийн засгийн дэд бүтэцтэй байсан явдал гэж үздэг. Мөн үйлдвэрлэлийг дэмжих бодлогыг хэрэгжүүлэхэд дараахь нийтлэг нөхцөлүүд нөлөөлсөн.

- **Улс төрийн болон макро эдийн засгийн тогтвортой байдал.**  
Улс төрийн тогтолцоо, төрийн албаны үйл ажиллагааны

хоорондын уялдаа маш нарийн зохицуулагдсан байсан. Мөн боловсон хүчнийг урамшуулах механизм Япон, Өмнөд Солонгос, Тайванд сайн хөгжсөн байжээ. Нөгөө талаас макро эдийн засгийн орчин харьцангуй тогтвортой байсан. Сүүлийн 30 жилд инфляцийн жилийн дундаж төвшин 9 орчим хувь байсан ба энэ нь урт хугацааны хувийн хөрөнгө оруулалт хийхэд суурь нөхцөл болсон гэж үздэг.

- **Дэд бүтэц.** Эрчим хүч, тээвэр холбооны боловсронгуй тогтолцоо, нийгмийн дэд бүтэц, өндөр боловсрол нь эдийн засгийн өсөлтөд чухал нөлөөлсөн.
- **Хөрөнгө оруулалт болон хуримтлал.** Хөрөнгө оруулалт, хуримтлалын бодлогыг төвлөрсөн бодлогоор зохицуулах боломж багатай. Харин татварын бодлого нь эдийн засгийн хөгжилд чухал үүрэг гүйцэтгэдэг ба өрх гэрт ирээдүйн хуримтлал хийх нөхцөлийг бүрдүүлвэл энэ нь хөрөнгө оруулалт өөрөө хурдацтай өсдөг гэдгийг харуулсан.
- **Бүтээгдэхүүний чанар, үнийн өрсөлдөөн** нь зах зээлийн хуулиар үндсэндээ зохицуулагддаг. Гэхдээ зах зээл бүрэн төгөлдөржөөгүй нийгэмд чанарыг урамшуулах тодорхой механизм шаардлагтай байдаг. Гэхдээ төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн үед чанарын асуудалд хяналт тавих, урамшуулах асуудал ямар хүндрэлтэй байдгийг туршлага харуулсан. Өмнөд Азын орнуудын чанарыг сайжруулах механизм нь экспортыг дэмжих, өөрийн бүтээгдэхүүнийг дэлхийн зах зээлд өрсөлдүүлэх явдал гэж үзэж байсан
- **Экспортод түшиглэсэн хөгжлийн стратеги.** Дотоодын зах зээл жижиг, хүн амын орлого бага улс орнуудад экспортыг дэмжих асуудал зайлшгүй бөгөөд ялангуяа байгалын нөөц багатай Япон, Солонгос зэрэг орнуудын үйлдвэржилтэт энэхүү бодлого нэн чухал нөлөө үзүүлсэн.

Гэвч Энтэхэгийн Засгийн газар хүнд болон химийн үйлдвэрийг дэмжсэн бодлого явуулсан боловч амжилтанд хүрээгүй. Мөн Аргентин, Филиппини, Индонези, Тайланд зэрэг орнуудын эдийн засаг 1980-аад оны дундаас унаж эхэлсэн. Дээрхи орнуудын хувьд ч үйлдвэрлэлийг дэмжихэд Засгийн газрын оролцоо нилээд өндөр байсан боловч тодорхой амжилтанд хүрээгүй.

1997 оны дундаас эхэлсэн зүүн өмнөд азын орнуудын санхүүгийн хямрал нь эдгээр орнуудын эдийн засгийн бүтэц тийм ч төгс бус гэдгийг харуулсан.

Газар зүйн байрлалын хувьд өөр боловч Монгол Улсын шилжилт нь Зүүн Европийн орнуудтай төстэй явагдаж байна. Үүний шалтгаан нь оршин тогтнож байсан улс төрийн тогтолцоо ба хэрэгжүүлж ирсэн эдийн засгийн бодлогоос хамааралтай гэж үзэх талтай юм. Азийн загвар нь эдийн засгийн байдал, ирээдүйн чиг хандлагыг хянасан улс төрийн тогтолцоо байх шаардлагатай гэж үздэг. Зүүн Европийн загвар нь улс төр, эдийн засгийн салбарт шинэчлэлтийг бодитойгоор, эргэж буцалтгүйгээр хослуулан хийнэ гэсэн номлолтой байдаг. Үүний анхны алхам нь өмч хувьчлалыг хэрэгжүүлэх, хувийн сектор ба банкны тогтолцоог хөгжүүлэх, төрийн оролцооны цар хүрээг багасгахад чиглэгддэг. Хэдийгээр улс төр, захиргаадалтын хуучны уламжлалаас бүрэн ангижраагүй зарим хүндрэл байдаг боловч эдийн засгийн хөгжлийн арга замуудыг сонгох боломжтой байдаг. Юуны түрүүнд үнийг тогтворжуулах явдал юм. Үүний тулд төсвийн болон инфляцийн тодорхой загварыг сонгоно. Инфляцийн загвар нь төсвийн алдагдлыг зээлээр нөхөх ба энэ хэмжээгээр мөнгөний нийлүүлэлт өснө гэж тооцдог. Гэхдээ инфляцийг зөвхөн хязгаарлах бус, харин төрийн зүгээс түүнтэй зохицсон бодлого явуулах нь чухал юм.

Шилжилтийн үед үйлдвэрлэлийг сэргээн тогтворжуулах нь хоёрдогч гол асуудал болон дэвшигддэг бөгөөд үүний дүнд ажилгүйдэл, ядуурлыг бууруулах боломж бүрдэж энэ чиглэлээр зарцуулсан хөрөнгийг шилжилтийн

өртөг гэж үздэг юм. Шилжилтийн үеийн үйлдвэрлэлийн уналтыг зөвхөн эрэлт, нийлүүлэлт (үйлдвэрлэлт) хоёрын харьцаа алдагдсанаас шалтгаалж байна гэж үздэггүй юм. Энэ нь хуучин ЗХУ ба ЭЗХТЗ-ийн гишүүн орнуудын хуваарилалтын буруу зарчим дээр тулгуурласан нөөцийн байршилт ба үйлдвэрлэл хоёрын зохисгүй харьцаанаас шалтгаалдаг. Бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний үйлдвэрлэлийг урамшуулах микро эдийн засгийн нэг гол механизм бол өрсөлдөгч чадвар бүхий шинэ технологийг нэвтрүүлэх явдал юм. Орон тус бүрийн онцлогоос шалтгаалан үйлдвэрлэлийн уналтын үргэлжлэх хугацаа нь өөр өөр байдаг. Үйлдвэрлэлийн уналтын гол шалтгааны нэг нь хуучин ЗХУ болон ЭЗХТЗ задарсан явдал юм. Өөр анхаарал татах асуудал бол хөрөнгө оруулалт, ялангуяа удаан хугацааны хөрөнгө оруулалтын өгөөжийг нэмэгдүүлэх асуудал юм. Монголын одоогийн эдийн засгийн орчинд өмчийн шинэ харилцаан дээр тулгуурласан үйлдвэр, аж ахуйн газруудаг ашигтай ажиллуулна гэдэг санхүүгийн хувьд нэлээд бэрхшээлтэй. Иймд үнийг тогтворжуулах явдал бол үйлдвэрлэлийг сэргээхэд зохих хэмжээний нөлөө бүхий алхам юм. Өөрөөр хэлбэл инфляцийн нэг оронтой тоонд хүргэх талаар дэвшүүлсэн зорилго нь үйлдвэрлэлийг сэргээхэд эерэг нөлөө үзүүлэх талтай. Иймээс мөнгөний хатуу бодлогоор нэлээд асуудлыг шийдвэрлэхээс гадна төсвийн орлогыг бүрдүүлэхийн тулд татварын суурийг нэмэгдүүлэх, үйлдвэрлэлийг өсгөх шаардлага урган гарч байна.

Ихэнхи хөгжиж буй орнуудын хувьд гадаад, дотоод нийлүүлэлтийн тэнцвэрт байдал алдагдсан, ялангуяа гадаад худалдааны болон төсвийн алдагдал ихтэй, инфляцийн түвшин өндөр, эдийн өсөлт саарах хандлага нийтлэг байсан. 1980 оны дундаас Олон улсын Валютин сан бага орлоготой гишүүн орнуудын хувьд дунд хугацааны бүтцийн өөрчилөлт хийх шаардлагатай бөгөөд үүнд санхүүгийн тодорхой нөөц хэрэгтэй гэдэгт анхаарал төвлөрүүлж эхэлсэн. Бүтцийн өөрчилөлтийн бодлого нь голлон эрэлтийн удирдлагыг зохицуулах асуудал дээр төвлөрдөг. ОУВС 1994 оны сүүлээр нийт 34 оронд энэхүү бүтцийн өөрчилөлтийн хөтөлбөрийг

хэрэгжүүлж байна. Монгол улс сүүлийн 10 жилд олон улсын банк, санхүүгийн байгууллагы дэмжлэг туслалцаатайгаар макро эдийн засгийг тогтворжуулах, хувийн хэвшилд тулгуурласан нээлттэй эдийн засгийн бүтцийг бий болгоход нилээд ахиц оллоо. Ялангуяа үнэ, ханш, гадаад худалдааг чөлөөлөх, банк, санхүүгийн тогтолцоог шинэчлэх, бүтцийн өөрчлөлт хийх, эрх зүйн орчинг зах зээлийн нөхцөлд тохируулан бүрдүүлэх, нийгмийн хамгааллын сүлжээний үр ашгийг дээшлүүлэх чиглэлээр тодорхой арга хэмжээг авч хэрэгжүүлжээ.

Монгол улс 1990 оноос ардчилал, чөлөөт зах зээлийн эдийн засагт шилжих өөрчлөлт шинэчлэлийг эхэлсэн. 1992 оны эхээр батлагдсан шинэ Үндсэн хууль нь ардчилал, шинэчлэлийн үйл явцыг гүнзгийрүүлэх эрх зүйн баталгаа болов. Төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн харилцаанд шилжих түүхэн үеийн эхлэлийг эдийн засаг, нийгмийн хүрээнд хууль эрх зүйн орчинг бүрдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ , эдийн засгийн үзүүлэлтүүдийн байдалд тулгуурлан үндсэн гурван хэсэгт хувааж үзэв.

### **Шилжилтийн эхэн үе 1990-1993**


Гэхдээ төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн тогтолцооноос зах зээлийн эдийн засагт шилжих эхний алхамуудыг 1991 оноос хийж эхэлсэн бөгөөд шилжилтийн эдийн засагтай орнуудад тохиолддог нийтлэг бэрхшээлүүдийг Монгол улс нэгэн адил гэтэлсэн.

- Дотоодын нийт бүтээгдэхүүн 1990-1993 онд 20 орчим хувиар буурсан.
- Импорт 1990-1993 онд 2.6 дахин буюу 549.5 хүртэл сая ам.доллараар буурч, 374.5 сая ам.доллар болсон.
- Дотоодын нийт бүтээгдэхүүнд хөрөнгө оруулалтын эзлэх хувийн жин 1990 онд 32 хувь байсан бол 1992 онд 11 хувь болтлоо буурчээ.

- Бараа үйлчилгээний үнэ тариф, 1989 оноос хойш 1993 оныг дуустал хугацаанд 18.4 дахин өссөн.
- Ажилгүйдлийн түвшин 8.5 хувьд хүрсэн
- Хүн амын 30 гаруй хувь нь нэн ядуу байдалд аж төрөх болсон

Ийнхүү нэг талаас гэнэт нийлүүлэлтийн хэт шокоос болж инфляцийн түвшин эрс нэмэгдсэн.

Зураг 1



1992-1993 онд нэг талаас нэг хүнд ногдох ДНБ-ний өсөлт нөгөө талаас ДНБ-нд эзлэх хөрөнгө оруулалтын хэмжээ эрс буурсан,

Эдийн засгийг зах зээлийн харилцаанд шилжүүлэх үйл явц нь тус оронд бий болсон эдийн засгийн дотоод болон гадаад хямралтай давхацсанаас олон давхар хүндрэл бэрхшээлтэй тулгарсан. Хуучин ЗХУ-аас үзүүлж байсан зээл, тусламж зогсож, ЭЗХТЗ-ийн гишүүн орнуудын хамтын ажиллагаа, гадаад харилцааны нөхцөл эрс өөрчлөгдөн задарсан нь хямралыг гүнзгийрүүлэхэд шууд нөлөөлсөн.

Эдийн засгийн хямрал 1991-1992 онд оргилдоо хүрсэн. Энэ хугацаанд дотоодын нийт бүтээгдэхүүн жил тутам 6.3 хувиар буурч, хүн амын бодит



орлого 40 хувиар багасан нэг хүнд ногдох үндэсний орлогын үйлдвэрлэлээр Монгол улс 10-аад жилийн өмнөх түвшинд хүртэл ухарсан байсан.

Монгол Улс зах зээлийн эдийн засагт шилжихэд өөрийн нь зарим онцлог байдал бас нөлөөлсөн.

Тус улс нь хүн ам цөөнтэй, газар нутаг өргөн уудам, үйлдвэр, хүн ам нь сийрэг таруу байршсан, экспорт нь зэс, жонш мал аж ахуйн гаралтай ноос арьс шир зэрэг цөөн нэрийн бүтээгдэхүүнээс бүрддэг, тэр нь дэлхийн зах зээлийн үнийн хэлбэлзэлд байнга өртөмтхий, импортын барааны бүтцэд нь нефть, машин тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгсэл голлох байр суурьтай, эдийн засагт нь улсын үйлдвэр аж ахуйн газар зонхилсон бүтэц бүхий онцлогтой байсан.

ДНБ-ний салбаруудын жилийн дундаж өсөлт, бууралт 1993 зэр.үнээр

	1981-1985	1986-1990	1991-1993	1994-1996	1997-2000
<b>Нэмэгдсэн өртөг</b>	6.5	2.5	-6.3	5.5	3.3
Аж үйлдвэр	9.2	4.3	-8.1	8.2	2.4
хөдөө аж ахуй	5.4	0.1	-2.4	8.5	2.4
барилга	3.3	2.2	-32.4	13.3	4.0
тээвэр	7.2	-1.3	-13.2	2.5	4.7
холбоо	10.7	7.1	-7.1	2.0	9.2
худалдаа	4.8	5.1	-9.8	1.3	5.7
үйлчилгээ	4.0	3.2	-0.6	5.2	4.7

1990-1993 онд аж үйлдвэр, барилга, тээвэр, худалдааны салбарын нэмэгдсэн өртөг 20-50 гаруй хувиар буурсан нь ДНБ-ний уналтад голлон нөлөөлсөн. Эдгээр нь голлон гадаад эдийн засгаас хамааралтай салбарууд байна. Харин мал аж ахуйн салбар шилжилтийн хүнд үед хамгийн бага уналттай байна. Үүнтэй уялдаж ДНБ-нд эзлэх хөдөө аж ахуйн салбар 30 гаруй хувьтай болсон нь хямралын хүнд үеийг даван туулахад нааштайгаар нөлөөлсөн.

## ДНБ-ний салбарын бүтэц, оны үнээр

	1881-1985	1986-1990	1991-1993	1994-1996	1997-2000
Нэмэгдсэн өртөг	100.0	100.0	100.0	100.0	100.0
Аж үйлдвэр	30.3	33.0	31.0	25.1	23.5
хөдөө аж ахуй	15.0	15.2	32.4	36.8	33.0
Барилга	4.6	5.7	1.9	3.1	3.4
тээвэр,холбоо	12.3	12.7	5.0	5.4	6.9
Худалдаа	23.2	18.6	16.8	16.4	19.6
үйлчилгээ	14.6	14.8	12.9	13.2	13.6

1991-1993 он бол тус улс төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн эдийн засагт шилжих анхны алхамуудыг хийж эхэлсэн эхний үе шат юм. Энэ хугацаанд бодлогын чанартай доорхи арга хэмжээнүүд авч хэрэгжүүлжээ.

- \* Бараа, үйлчилгээний үнэ тарифыг үе шаттай чөлөөлсөн.
- \* Монголын үндэсний валют төгрөгийг дотооддоо хөрвөдөг болгох зорилгод нийцүүлэн түүний гадаад валюттай харьцах ханшийг чөлөөтэй хөвөх тогтолцоонд шилжүүлэх арга хэмжээг 1993 оноос хэрэгжүүлсэн.
- \* Мөн хөрөнгө оруулалтын эрхийн бичиг гаргаж Монголын бүх иргэд гарааны ижил нөхцөлөөс 10000 төгрөгийн үндсэн хөрөнгийг хувьчилж авах эрхтэй болсон. Үүний үр дүнд худалдаа, нийтийн хоол, ахуй үйлчилгээний салбаруудыг хөрөнгө оруулалтын эрхийн бичгээр хувьчилсан. Монголын эдийн засгийн үндсэн тулгуур болсон малыг 1991 оны сүүлч 1992 оны эхээр эрхийн бичгээр үнэ төлбөргүй хувьчилж үндсэнд нь дуусгасан.
- \* 1991 оноос банкны 2 шатлалтай тогтолцоонд шилжсэн.
- \* Засгийн газраас төсөв, мөнгөний хатуу бодлого явуулж, макро түвшин дэх удирдлага зохицуулалтын үүргийг дээшлүүлэхэд онцгой анхаарсан.

- \* Монголын эдийн засгийг тогтворжуулах болон бүтцийг өөрчлөх чиглэлээр ОУВС-тай хамтран төсөл хэрэгжүүлэх зорилгоор Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк, хандивлагч орнууд, олон улсын байгууллагуудтай дунд хугацааны хөтөлбөрийг боловсруулж батлан хэрэгжүүлж эхэлсэн.
- \* Төрөөс зах зээлийн эдийн засгийн харилцааг зохицуулах гол хэрэгсэл болох татварын багц хуулиуд, төсвийн болон шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай, гадаадын хөрөнгө оруулалт, валют, статистик, нягтлан бодох бүртгэл, нийгмийн даатгалын тухай зэрэг зах зээлийн эдийн засгийн суурь хуулиудыг 1993-1995 онуудад батлан хэрэгжүүлж эхэлсэн.


### **1994-1996 он**

Монгол Улс ийнхүү эдийн засгийн шилжилтийг богино хугацаанд эрчимтэй хэрэгжүүлэн эхэлсний үр дүнд зарим нааштай ахиц, гарах төлөв байдал 1994 оноос ажиглагдсан.

- \* Эдийн засгийн уналт 1993 онд саарч зогсон, улмаар ДНБ 1994 он 2.3 хувь, 1995 онд 6.3 хувь, 1996 онд 2.4 хувь өссөн.
- \* 1992 онд 325 хувь хүрч байсан инфляцийн түвшин 1994 онд 66.3, 1995 онд 53.1 хувь болж, буурах хандлагатай болсон.
- \* Дэлхийн зах зээл дээр зэсийн үнэ нэмэгдсэн нь гадаад худалдааны тэнцэл эерэг гарах нөхцөлийг бүрдүүлсэн
- \* ДНБ-д эзлэх салбарууд бүтэц өөрчлөгдөж уул уурхай, хөдөө аж ахуйн салбарын эзлэх хувийн жин нэмэгдсэн


Өмчийн харилцааны өөрчлөлтөд тулгуурлан эдийн засгийн удирдлагын тогтолцоо, арга механизмыг өөрчлөн шинэчлэх, түүний хууль зүйн үндсийг буй болгох, зах зээлийн дэд бүтцийг бүрдүүлж зүгшрүүлэх

талаар бодлоын чанартай арга хэмжээ, макро түвшний удирдлагыг сайжруулах ажлыг 1992 оны сүүлээс эрчимжүүлсэн. ОУВС-тай хамтран боловсруулж тохиролцсон Монголын эдийн засгийг тогтворжуулах, бүтцийг өөрчлөх болон Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк, хандивлагч орнууд, олон улсын байгууллагуудтай дунд хугацааны хөтөлбөрийг батлан хэрэгжүүлж эхэлсэн байна.



Засгийн газраас сүүлийн жилүүдэд төсөв, мөнгө, зээл, валютын цэгцтэй бодлого явуулж, макро түвшин дэх удирдлага зохицуулалтын үүргийг дээшлүүлэхэд онцгой анхаарч байна. Төрөөс зах зээлийн эдийн засгийн харилцааг зохицуулах гол хэрэгсэл болох татварын багц хуулиуд, төсвийн болон шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай, гадаадын хөрөнгө оруулалт, валют, статистик, нягтлан бодох бүртгэл, нийгмийн даатгалын тухай хуулиудыг анх удаа 1993-1995 онуудад батлан хэрэгжүүлж эхэлсэн.

1995 онд ДНБ-ний өсөлт өндөр болсон нь (6.3 хувь) дэлхийн зах зээл дээр ноолуур, зэсийн үнэ өсч, нефтийн үнэ буурч гадаад худалдааны нэн тааламжтай нөхцөл бүрдэн, экспортын орлого зөвхөн үнийн өсөлтөөс 100 орчим сая ам.доллар нэмэгдсэн явдал шууд нөлөөлсөн.



Мөн ноолуур, алтны хэд хэдэн үйлдвэрлэл ашиглалтад орж алт олборлолт нэмэгдсэн.

Эдийн засагт үндсэндээ дангаар ноёрхож байсан төрийн өмчийг задлан хувьчлах тухай хууль үйлчилж эхэлснээс хойшхи хугацаанд хувьчлахаар анх төлөвлөж байсан хөрөнгө үндсэндээ хувьчлалд хамрагдаж худалдаа, нийтийн хоол, ахуй үйлчилгээ, аялал жуулчлалын байгууллагуудын 90-100 хувь, мал сүргийн 90 гаруй хувь хувийн өмчид шилжиж, улсын үйлдвэрийн газруудын дийлэнх нь хөрөнгө оруулалтын эрхийн бичгээр их хувьчлалд хамрагдсан. Хувьчлалын үр дүнд нийт 3800 гаруй хувьчлагдсан аж ахуйн нэгж бий болсон. Өмч хувьчлалын хүрээнд зарим барилга байгууламжийг гадаад, дотоодын байгууллага, хувь хүмүүст худалдах, дуусаагүй барилга байгууламжийг хувьчлалд хамруулах, үнэт цаасны хоёрдогч зах зээл нээх ажлыг хэрэгжүүлсэн.

Төрийн өмчийг хувьчлахын зэрэгцээ хувийн хэвшлийн аж ахуйнууд шинээр бий болсон Монголын эдийн засагт бүтцийн өөрчлөлт гарч хувийн секторын эзлэх байр суурь бэхжиж байна. 1996 оны байдлаар тус улсын дотоодын нийт бүтээгдэхүүний 60 гаруй хувийг хувийн секторт үйлдвэрлэжээ.

Хүн амын ихэнх хэсэг өөрийн гэсэн өмчтэй болж анхны хуримтлалаа бий болгож байна. Чөлөөт үнэ, ханшны тогтолцоонд шилжих, гадаад худалдааг либеральчлах дэс дараатай алхмуудыг хийснээр хүнс, өргөн хэрэглээний барааны хангамж сайжирч зохих нөөцтэй боллоо.

Хэдийгээр дээрхи нааштай хандлагууд гарч байсан боловч макроэдийн засгийн байдал бүрэн тогтворжоогүй, инфляцийн түвшин 53 хувьтай, банк санхүүгийн систем бүрэн төлөвшөөгүй байлаа. Нөгөө талаас монгол орны харьцангуй сул тал болох дотоод хуримтлал

хязгаарлагдмал, экспортын цөөн нэрийн бүтээгдэхүүнээс хамааралтай хэвээр байна.

#### ДНБ эцсийн ашиглалтаар, хувиар

	1981-1985	1986-1990	1991-1993	1994-1995
Нийт хэрэглээ	81.0	87.6	85.5	81.3
Хувийн хэрэглээ	53.7	57.5	60.6	62.8
Засгийн газрын хэрэглээ	27.3	30.1	24.9	18.6
Нийт хөрөнгө оруулалт	55.9	44.8	28.7	25.5
Цэвэр экспорт	-29.0	-28.2	-6.4	-1.5
Экспорт	23.3	24.4	67.3	55.0
Импорт	-52.2	-52.6	-73.7	-56.5
Тооцооны зөрүү	-7.9	-4.3	-7.9	-5.4
ДНБ	100	100	100	100

Эдийн засаг бүрэн тогтворжиж чадаагүй, суурь үнийг удаан хугацаанд хатуу чанд барьж ирснээс түлш эрчим хүчний байгууллагуудын санхүүгийн чадвар доройтож үйл ажиллагаа нь доголдох, төсөв, санхүү, банкны системд хүндрэл бэрхшээл гарч өрийн сүлжээ үүссэн, ажилгүйдэл өсч, хүн амын дотор нийгмийн ялгарал гарч, нийгмийн бэрхшээлтэй асуудлууд хуримлагдсаар байсан.


#### 1996-2000 он

1996-2000 онд Монгол улсын Засгийн газар, Олон улсын банк, санхүүгийн байгууллага, Хандивлагч орнуудтай хамтран шинэчлэлийг эдийн засаг, нийгмийн бүхий л хүрээнд эрс хурдасгах зорилгоор макро эдийн засгийг тогтворжуулах, бүтцийн өөрчлөлтийг эрчимжүүлэх, улсын хэвшлийн хүрээг багасгах, хувийн хэвшлийн хөгжлийг дэмжихэд чиглэсэн арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэний үр дүнд **макро эдийн засгийн байдалд нааштай хадлагууд гарсан байна.**

- ДНБ-ны жилийн дундаж өсөлт 2.3 хувь

- Инфляцийн түвшин 53 хувиас 6-10 хувь болж буурсан
- Ажилгүйдэл 4.6 хувь
- Гадаад валютийн нийт албан нөөц 191 сая ам.дол буюу 14 долоо хоногийн импорттой тэнцүү болсон
- Төсвийн урсгал тэнцлийн ашиг ДНБ-ны 3 хувь
- Гадаад худалдааны нийт эргэлт нэг тэрбум ам.дол гаруй болжээ

**Эдийн засгийн өсөлт.** 1996-2000 онд гадаад эдийн засгийн орчин нилээд таагүй байсан боловч Дотоодын нийт бүтээгдэхүүний жилийн дундаж өсөлт 2.3 хувь орчим болжээ. Нэг хүнд ногдох ДНБ-ний өсөлт 2000 онд 1996 оныхоос 3.8 хувиар өссөн байна. Өнгөрсөн 4 жилд ДНБ-ны салбарын бүтцэд мал аж ахуй, уул уурхай, худалдаа үйлчилгээний салбар зонхилох байр суурийг эзэлсэн хэвээр байгаа бөгөөд эдгээр салбар нь эдийн өсөлтийг хангах гол хөшүүрэг болжээ. Харин боловсруулах аж үйлдвэрийн салбарын эзлэх хэвийн жин буурах хандлагатай байна. ДНБ-д эзлэх хөрөнгө оруулалтын хэмжээ 23 хувиас 25 хувь болж өсж байгаа хэдий ч үйлдвэрлэл-хөрөнгийн харьцаа (ICOR) доогуур байгаа нь хөрөнгө оруулалтын бүтээмж доогуур байгааг харуулж байна.



ДНБ –ны өсөлт 1996 онд 2.4 хувь, 1997 онд 4.0 хувь, 1998 онд 3.5 хувь, 1999 онд 3.2 хувь өсч, хүн амын жилийн дундаж өсөлтөөс давж байна. Харин 2000 онд эдийн засгийн өсөлт саарч -1.4 болжээ. Үүнд голлон мал аж ахуй бүтээгдэхүүний үйлдвэрлэл 20 орчим хувь буурсан нь нөлөөлжээ<sup>1</sup>.

**Инфляци.** Инфляцийн түвшин 1996 онд 44.6 хувь байсан бол жил дараалан буурч 2000 оны эцэст 8.1 хувь болж нэг оронтой тоонд шилжсэн байна. Инфляцийн түвшинг буурахад дараахи хүчин зүйлүүд нөлөөлжээ.


- Мөнгөний нийлүүлэлт тогтвортой байсан
- Улсын нэгдсэн төсвийн урсгал тэнцэл ашигтай байсан
- Гадаад валютийн нөөц нэмэгдсэн, ханш харьцангуй тогтвортой байсан.
- Өргөн хэрэглээний барааны гадаад зах зээлийн орчин тогтвортой байсан зэрэг нь голлон нөлөөлжээ.

Инфляци буурснаар үйлдвэрлэл, үйлчилгээг нэмэгдүүлэх, хүн амын бодит орлогыг өсгөх, нөгөө талаас олон улсын байгууллагуудтай хамтран ажиллах бололцоог бүрдүүлдэг билээ. Өнгөрсөн 4 жилд инфляцийн түвшинг 15.0 хувиас хэтрүүлэхгүй байх зорилт дэвшүүлсэн бөгөөд 1998 онд 6 хувь, 1999 онд 10 хувь, 2000 онд 8.1 хувь болж тавьсан зорилт үндсэндээ биелжээ. Инфляцид улирлын хүчин зүйл ялангуяа хүнсний бүтээгдэхүүний үнийн өөрчилөлт голлон нөлөөлж байна. Ихэвчлэн 2 сараас 6 сарын хооронд инфляци өсч 7-с 11 сард буурдаг хандлага сүүлийн жилүүдэд нилээд давтагдаж байна

---

<sup>1</sup> Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний тооцоог цаашид боловсронгуй болгох шаардлагатай





Энэ нь төсөв, мөнгөний бодлого явуулахдаа Монгол улсын улирлын хэлбэлзлийг харгалан үзэх шаардлагатайг харуулж байна. Өнгөрсөн 4 жилд өргөн хэрэглээний барааны бүлгээр авч үзвэл хамгийн өндөр өсөлт нь орон сууц, түлш цахилгааны үнийн өсөлт байна.

**Ажилгүйдэл.** 1995 онд албан ёсны бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 45.1 мянга байсан бол 2000 онд 38.5 мянган хүн болон буурч, эдийн засгийн идэвхтэй хүн амын тоонд харьцуулсан ажилгүйдлийн түвшин 4.6 орчим хувь болсон байна.

**Шигтгээ 1**

ДНБ-ны өөрчилөлт, ажилгүйдлийн сөрөг хамаарлыг Окины хууль харуулдаг.

ДНБ-ны бодит өөрчилөлт = 3%- 2\* Ажилгүйдлийн түвшингийн өөрчилөлт

Хэрэв ажилгүйдлийн түвшин өөрчилөлтгүй тогтвортой байвал Эдийн засаг

3 орчим хувь өсөх боломжтой гэж үздэг.

Монгол улсын хувьд албан бус сектор болон улирлын ажил хийдэг хүмүүс нилээдэг байдаг тул дээрхи томьёололын дагуу нарийвчилсан судалгаа хийхэд нилээд хүндрэл гардаг.


*Тэмдгэлгээ: Манай хүний нөөцийн статистикаар ажил эрхлээгүй 200 мянга орчим хүн байдаг. Гэвч статистикийн олон улсын аргачлалаар “ Тухайн улсын хуулиар зөвшөөрөгдсөн хөдөлмөрлөх насны хөдөлмөр эрхлэх чадвартай, цалин хөлстэй ажил болон хувиараа хөдөлмөр эрхлэдэггүй, тухайн үед ажиллахад бэлэн, ажил хайж байгаа Хөдөлмөр зохицуулалтын албанд бүртгүүлсэн хүмүүсийг ажилгүйчүүдэд хамааруулдаг”.  
Ажилгүйдэл түвшин = Ажилгүйдлийн тоо / Хөдөлмөрийн нөөц*

**Гадаад валютын цэвэр нөөц** 1996 оны эцэст гадаад валютын цэвэр албан нөөц 56.8 сая ам. доллар байсан бол 1997 онд 90.0 сая, 1998 онд 80.3 сая, 1999 онд 116.9 сая, 2000 онд 140.7 сая ам.дол болж, гадаад валютын цэвэр нөөц тогтворжиж үндсэндээ импортын 10-13 долоо хоногийн хэрэгцээг хангахуйц хэмжээнд хүрсэн байна.

**Төсөв, татварын** бодлого нь макро эдийн засгийн байдлыг тогтворжуулах, дотоод санхүүгийн нөөцөөс улсын хэвшилд ногдох хэсгийг хязгаарлах, хувийн хэвшлийг дэмжихэд чиглэгдэж байлаа. Энэ зорилтын хүрээнд төсвийн орлогын шинэ эх үүсвэрийг бүрдүүлэх, зарлагыг оновчтой хуваарилах чиглэл чухал байлаа. Татварын дарамтыг бууруулах зорилгоор албан татварын багц хуульд нэмэлт, өөрчлөлт оруулан аж ахуйн нэгж болон хүн амын орлогын албан татварын шатлалыг цөөрүүлж, хувь хэмжээг багасгаснаар татварын дарамтыг 16-57 хувиар бууруулсан байна. Мөн тодорхой хугацаанд импортын барааны гаалийн албан татварыг тэглэж мөрдүүлсэн бөгөөд уг татварыг сэргээхдээ хувь хэмжээг нь өмнө мөрдөж байснаас бараг 3 дахин бага байхаар тогтоожээ. Мөн татварын бааз суурийг нэмэгдүүлэх, татварын тогтолцоог боловсронгуй болгох, зарлагын удирдлагыг хүчтэй болгоход чиглэсэн төсөвлөх, бүртгэх, хяналт тавих


тогтолцоог төгөлдөржүүлэх, төсвийн удирдлагын төвлөрлийг аажмаар сааруулах ажлуудыг хэрэгжүүлсэн. Мөн банкны системээс Засгийн газарт олгох цэвэр зээлийг ДНБ-ий 1-3,5 хувиас хэтрүүлэхгүй байх бодлого баримталж ирэв. Дээрхи арга хэмжээний үр дүнд 1996-1999 онд ДНБ-д эзлэх төсвийн нийт орлого 26.2-29.3 хувь, зарлага 36.0-39.1 хувь, нийт алдагдал 8.2-12.6 хувь, урсгал тэнцлийн ашиг –0.6-4.5 хувьд байлаа.

**Мөнгө, зээл, ханш** 2000 оны эцэст мөнгөний нийт нийлүүлэлт 258.8 тэрбум төгрөгт хүрч, оны эхнийхээс 2.2 хувь, мөнгөнийн нийт эргэц 8.4 хувиар буурсан байна. Мөнгөний нийлүүлэлтийг бүтцээр авч үзвэл банкнаас гадуурхи мөнгө 39 хувийг, төгрөгийн хугацаат хадгаламж 22.8 хувийг хугацаагүй хадгаламж 11.5 хувийг гадаад хадгаламж 26.7 хувийг тус тус эзэлж байна. 2000 оныг 1996 онтой харьцуулахад гадаад валютийн хадгаламж 2.3 дахин, төгрөгийн хугацаат хадгаламж 67.8 хувь өссөн байна. Мөнгөний нийлүүлэлтийг нэмэгдүүлэхэд гадаад цэвэр активийн өсөлт нь голлох үүрэг гүйцэтгэсэн байна.




2000 оныг 1996 онтой харьцуулахад гадаад цэвэр актив 2.7 дахин өсч, 201.7 тэрбум төгрөг болсон байна. 1996 онд валютийн хугацаат хадгаламжийн хүү 3,6-42,3 хувь байсан бол 2000 оны эцэст 1,0-12 хувь

болж буурсан байна. Мөнгөний нийлүүлэлтийг зохицуулах мөнгөний бодлогын хэрэгслүүдийн үр нөлөөг сайжруулж , төв банкны үнэт цаасны хэмжээ, хүүг тухайн үеийн мөнгөний нийлүүлэлтийн байдалтай уялдуулан тогтоож байсан нь үнийн өсөлт тогтворжих нөхцөлийг бүрдүүлсэн байна. Өнгөрсөн 4 жилийн хугацаанд төгрөгийн гадаад валюттай харьцах нэрлэсэн ханш харьцангй тогтвортой байжээ.



Дотоодын валютийн захыг хөгжүүлэх, үндэсний мөнгөн тэмдэгтийн үнэгүйдлээс хамгаалах, валютийн ханшийг тогтвортой байлгах үүднээс валютийн бирж ажиллуусан нь тодорхой үр дүнтэй болсон.



**Гадаад худалдаа, төлбөрийн тэнцэл.** Зүүн өмнөд Азийн хямрал гадаад орчны таагүй байдлаас манай экспортын гол нэрийн бүтээгдэхүүний үнэ дэлхийн зах зээл дээр буурсан, нөгөө талаас бодит ханшны чангаралт зэрэг нь төлбөрийн тэнцэлд таагүй нөлөөлж байв.

**Урсгал данс.** 1997 онд төлбөрийн тэнцлийн урсгал дансны байдал сайжрах хандлагатай байсан боловч зэс, алт, ноолуурын үнийн бууралтаас шалтгаалан 1998 онд урсгал дансны алдагдал 95 орчим сая ам. доллар болсон бөгөөд 2000 оны эцэст 140.9 сая доллар болсон байна. Өнгөрсөн 4 жилийн хугацаанд экспортын үйлдвэрлэл 13 орчим хувь өссөн нь импортын өсөлтөөс 2 дахин бага байна. Экспортын бүтцэд уул уурхай салбарын бүтээгдэхүүний эзлэх хувь нэмэгдэж байгаа хэдий ч дэлхийн зах зээлийн үнийн хэлбэлзэлд өртөмтгий хэвээр байна. Нөгөө талаас бодит ханшны чангаралттай уялдан импортын бүтээгдэхүүний хэмжээ нэмэгдэх хандлагатай байна. 1996 онд экспортын 50 орчим хувийг зэс эзэлж байсан бол 2000 онд 30 орчим хувь болон буурч, харин алт, мах, ноолууран эдлэлийн эзлэх хувийн жин өссөн байна. Зэсийн экспорт биет хэмжээгээр 7,1 хувь өссөн боловч үнийн дүнгээр 100 гаруй сая доллараар буурсан

байна. Харин аялал жуулчлал хөгжиж байгаатай уялдан үйлчилгээний экспорт өсөх хандалгатай байна. Мөн хувийн шилжүүлэг 8 дахин өсчээ. Энэ нь нэг талаас онгол гадаадад нилээд хэмжээгээр ажиллаж буйтай холбоотой.

**Хөрөнгийн данс.** Сүүлийн 4 жилд Монгол Улс олон улсын байгууллага, хандивлагч орнуудаас жилд дунджаар 140 орчим сая ам. долларын урт ба дунд хугацааны зээлийг ашиглаж байна. Харин 2000 онд сонгуулийн жил байсантай уялдан гадаадын зээл, тусламж нилээд хүлээгдэх хандлагатай байлаа. Мөн жилд ойролцоогоор 15 - 20 сая ам. долларын хэмжээтэй гадаадын шууд хөрөнгө оруулалт үйлдвэр, үйлчилгээний салбарт орж байна. Шууд хөрөнгө оруулалтын дийлэнхи нь уул уурхайн салбарт ногдож байна.

Монголын эдийн засаг нь гадаад худалдааны шок, экспортын цөөхөн нэр төрлийн бүтээгдэхүүний үнийн өөрчлөлтөд их мэдрэмтгий, амархан өртдөг хэвээр байна Өнгөрсөн 10 жилийн хугацаанд алтыг эс тооцвол экспортын бүтцэд мэдэгдэхүйц өөрчлөлт гараагүй байна. Дэлхийн зах зээл дээрх зэс, алтны үнийн хэлбэлзэл Монголын эдийн засагт дотоод хүчин зүйлээс үл хамааран шууд нөлөө үзүүлдэг. Үүний зэрэгцээ сүүлийн үед хурцадсан Азийн хямрал Монголын эдийн засагт сөрөг үр дагавар үзүүлсэн. Энэ асуудлыг шийдвэрлэхэд экспортын бүтээгдэхүүний нэр төрлийг өргөтгөх, хэмжээг нэмэгдүүлэх арга хэмжээ тодорхой нөлөө үзүүлнэ гэж тооцож байна. Дэлхийн банк дэд бүтцийг хөгжүүлэх, орлогыг тогтворжуулах Чилийн загварыг нэвтрүүлэх, ноолуурыг боловсруулалтыг сайжруулах зэрэг арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх нь зүйтэй гэсэн санал дэвшүүлсэн байна.

Анхаарал татах нөгөө гол асуудал бол дотоод хуримтлалыг нэмэгдүүлэх явдал юм. Одоогийн байдлаар Монгол орны нийт хөрөнгө оруулалтын тэн хагас нь гадаад эх үүсвэрээр санхүүжүүлэгдэж байна. Энэ

байдлыг удаан хугацаагаар үргэлжлүүлж болохгүйг анхааран дотоодын хуримтлалыг аль болох нэмэгдүүлэх нь чухал юм. Үүний тулд хувийн хуримтлалыг дэмжихэд чиглэсэн бүтцийн өөрчлөлтийн арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх нь чухал юм.

Нөгөө талаас банк, санхүүгийн салбарын бүтцийн өөрчлөлтийг улам гүнзгийрүүлэх нь чухлыг анхаарах ёстой. Өндөр өгөөжтэй хувийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, хувийн сектор дээр суурилсан эдийг засгийг хөгжүүлэхэд банкны найдвартай үйл ажиллагаа чухал ач холбодолтой юм. Инфляци буурна гэдэг нь банкид итгэх итгэлцэл бий болно гэсэн үг биш юм. Иймээс банкны найдвартай ажиллагааг хангахад бүтцийн өөрчлөлтийн зэрэгцээ зохих хуулийн болон бусад холбогдох өөрчлөлтийг хэрэгжүүлэх нь зүйтэй юм.

Эцэст нь улсын санхүүжилтын хэмжээ зохих түвшинд хүрсэн байх шаардлагатай. Шилжилтийн эхний үе шатанд төсвийн зардлыг хэмнэхэд чиглэгдсэн арга хэмжээ хэрэгжүүлж байсан бол одоо татварын тогтолцоог шинэчлэн нэвтрүүлэх нь чухал юм.

Дээрхи бодлогын чиглэлүүдийг харгалзан Монгол улсын хөгжлийн хэтийн төлөвийг Дэлхийн банкны загварыг ашиглан 2020 хүртэл үндсэн 3 хувилбараар тооцож үзлээ. Урт хугацааны прогнозчлол хийхэд гадаад орчин, байгал цаг уурын хувьсал, технологийн шинэчлэл, гадаад худалдааны нөхцөлийн өөрчилөлт зэргийг иж бүрэн төсөөлөх боломжгүй нь ойлгомжтой. Иймд Монгол улсын өнөөгийн бодит байдалд тулгуурласан дунд хугацааны хөгжлийн хандлагад илүү анхаарал хандуулав.

### **1. Доод хувилбар**

- Эдийн засагт огцом өөрчилөлт гарахгүй ялангуяа төрийн зүгээс реформын чанартай бодлогын арга хэмжээ сул, уламжлалт экспортын бүтээгдэхүүн бага зэрэг өсөх хандлагатай байх нөхцөлд ДНБ жилийн дундаж өсөлт 3 орчим хувь, нэг хүнд ногдох ДНБ 1000 орчим ам.дол болох таамаглал гарч байна.

### **2. Дунд хувилбар**

- Засгийн газраас бүтцийн өөрчилөлтийг эрчимжүүлэх ялангуяа банк, санхүүгийн системийг эрүүлжүүлэх, экспортын чиглэлийн үйлдвэрлэлийг дэмжих чиглэлээр бодлогын чанартай арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн нөхцөлд 2020 онд ДНБ-ны жилийн дундаж өсөлт 5 хувь, нэг хүнд ногдох ДНБ-ний хэмжээ 1600 ам дол болох тооцоо гарч байна. Энэ нөхцөлд уламжлалт экспортын бүтээгдэхүүн ялангуяа уул уурхайн болон боловсруулах салбарын бүтээгдэхүүний үйлдвэрлэл нэмэгдэнэ гэж тооцов.

### **3. Дээд хувилбар**

- Эдийн засаг, нийгмийн хүрээнд реформын чанартай бодлогын арга хэмжээнүүдийг эрчимтэй хэрэгжүүлэх замаар эдийн засгийн жилийн дундаж өсөлтийг 7 орчимд хүргэсэн нөхцөлд нэг хүнд ногдох ДНБ-ний хэмжээ 2200 ам дол болж байна. Мөн уламжлалт экспортын бүтээгдэхүүнээс гадна шинэ нэр төрлийн бүтээгдэхүүн экспорт тодорхой түвшинд хөгжинө гэж төсөөлөв.



Эдийн засгийн хөгжлийн түүхэнд бизнесийн мөчлөгийг урт, дунд, богино гэсэн гурван хэсэгт хувааж үздэг. Урт мөчлөгийг 54-60 жил ба Кондративийн гэж нэрлэдэг. Жуглерийн хэмээн нэрлэдэг Дунд мөчлөг нь 9-10 жил байдаг. Китчиний буюу богино мөчлөг нь 3-4 жил байдаг.

### **1.1. Эдийн засгийн гадаад орчин**

Дэлхийн эдийн засаг интеграцчилагдахын хэрээр эдийн засаг, санхүүгийн хувьд бүс нутгууд болон улс орнууд харилцан бие биенээсээ хамаарах хамаарал улам бүр нэмэгдэж байгаагийн илрэл нь Зүүн Өмнөд Ази болон ОХУ, Бразилд гарсан эдийн засаг, санхүүгийн хямрал юм. Энэхүү хямралаас шалтгаалан дэлхийн зах зээл дээр зарим түүхий эд, материал, бараа бүтээгдэхүүний үнэ сүүлийн 25 жилд байгаагүй хамгийн доод хэмжээндээ хүртэл унасан. Нөгөө талаас дэлхийн зах зээлийн эрэлт буурч, улмаар нийлүүлэлт багассан нь цөөн нэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж экспортолдог улс орнуудын эдийн засагт ихээхэн бэрхшээл учруулсан. Дэлхийн эдийн засгийн өсөлт 1997 онд 4.2 хувь 1998 онд 2.5 хувь болж өсөлтийн хурдац нь саарсан байна.

1998 оны 8 сард рублийн ханш гэнэт унаснаас хойш Оросын эдийн засгийн хямрал үргэлжилсээр байна. ОХУ-ын гадаадын шууд хөрөнгө оруулалт 1997 онд 6.2 тэрбум ам.доллар байсан бол 1998 онд 1.2 тэрбум ам.доллар болтлоо буурсан байна.

Хэдийгээр Азийн эдийн засгийн хямрал Хятадын эдийн засагт бага хэмжээгээр нөлөөлж, өсөлтийн хурдац нь саарсан ч тус улс гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг дэмжиж, 200 тэрбум юаны улсын хөрөнгө оруулалтыг тодорхой салбаруудад хийж, мөнгө, санхүүгийн салбарыг өргөтгөх бодлого явуулснаар эдийн засгийн өсөлтөө хадгалахаар чармайж байна. Хятадын ДНБ-ий өсөлт 1999 онд 7.0 хувь, 2000 онд 6.5 хувьтай байна.

Зүүн Өмнөд Ази болон дэлхийн зарим бүс нутгийг хамарсан эдийн засгийн хямрал, бараа бүтээгдэхүүний дэлхийн зах зээлийн уналт, улс төрийн дотоод тогтворгүй байдал зэрэг нь манай эдийн засагт сөргөөр нөлөөлж, сүүлийн 2 жилд багагүй бэрхшээл тулгарч байна. Манай экспортын бүтээгдэхүүний 50-80 хувийг эзэлдэг зэс, алт, ноолуурын үнийн бууралтаас экспортын орлого 1998-1999 онд жилд дунджаар 100 гаруй сая ам доллараар, төсвийн орлого 30.0 гаруй тэрбум төгрөгөөр буурч, төсвийн зарлага санхүүжилт хүндрэх, энэ нь эргээд нийт эдийн засгийн байдал ялангуяа банк санхүүгийн байдалд хүчтэй нөлөөлж байна. Энэ нь цөөн нэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэн экспортолдог эдийн засгийн бүтцийн султалыг харуулж байгаа бөгөөд гадаад нөхцөл байдлын өөрчлөлтийг манай эдийн засаг ямар амархан мэдэрч буйг харуулсан сургамж үлдээж байна. Нөгөө талаас Засгийн газар ойр ойрхон солигдож байснаас гадаад орнууд, олон улсын байгууллагаас орж ирэх зээл, тусламж хугацаа хойшлох, хүлээх хандлага гарч байсан зэргээс шалтгаалан төсвийн урсгал тэнцэл 1998 оны эцэст алдагдалтай гарч, төсвийн нийт алдагдал өмнөх 2 жилийнхээс ихээхэн нэмэгдэж, дотоодын нийт бүтээгдэхүүний 11.7 хувь болж ээ.

ОУВС-аас гаргасан мэдээгээр Өмнөд Солонгос, Тайланд, Малайз, Филиппин зэрэг хямралд ихээр өртсөн орнуудын эдийн засаг тогтворжих хандлагатай боллоо. Оны эхний улирлын байдлаар Өмнөд Солонгосын аж үйлдвэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл өмнөх оны мөн үеийнхээс 18.4

хувиар, Сингапурынх 6.2 хувиар, Тайландынх 5.8 хувиар тус тус өссөн байна.

Дэлхийн эдийн засгийн өсөлт 1999 онд 3.5 хувь, 2000 онд 4.8 хувь болж сэргэх хандлагатай болж байна.

Дэлхийн эдийн засгийн өсөлт

	1999	2000
Дэлхийн эдийн засгийн өсөлт	3.5	4.8
Хөгжсөн орнууд	3.4	4.1
АНУ	3.0	3.8
Япон	4.2	5.0
Герман	0.8	1.7
Хөгжиж буй орнууд	3.8	5.8
Африк	2.3	3.0
Хятад	6.1	6.9
Шилжилтийн эдийн засагтай орнууд	2.6	5.8

Азийн хөгжиж буй орнуудын эдийн засгийн зарим үзүүлэлтүүд, 1996-2000 он


Үзүүлэлтүүд	1996	1997	1998	1999	2000
<b><i>ДНБ-ий өсөлт</i></b>	7,4	6,2	2,6	4,4	5,1
<b><i>Азийн хөгжиж буй орнууд</i></b>					
Шинээр аж үйлдвэржсэн эдийн засгууд	6,3	6,0	-1,4	2,3	4,3
БНХАУ	9,6	8,7	7,8	7,0	6,5
Монгол	2,4	4,0	3,5	3,4	3,1
Төв Азийн БНУлсууд	1,1	3,5	0,4	-	-
Зүүн Өмнөд Азийн орнууд	7,1	4,0	-6,9	0,8	2,8
Өмнөд Азийн орнууд	7,2	4,7	5,7	5,5	5,8
Номхон далайн орнууд	3,1	-3,4	0,1	-	-
<b><i>Инфляцийн түвшин</i></b>					
<b><i>Азийн хөгжиж буй орнууд</i></b>	7,3	4,6	6,5	3,7	4,1
Шинээр аж үйлдвэржсэн эдийн засгууд	4,3	3,5	3,8	1,1	2,3
БНХАУ	8,4	2,8	-0,8	2,0	3,0
Монгол	53,2	20,5	6,0	10,0	9,7
Төв Азийн БНУлсууд	42,3	21,6	10,1	-	-
Зүүн Өмнөд Азийн орнууд	6,6	5,6	21,0	8,3	6,4
Өмнөд Азийн орнууд	9,5	7,3	13,0	7,6	7,2
Номхон далайн орнууд	8,6	4,0	8,6	-	-
<b><i>Урсгал дансны тэнцэл (ДНБ-д эзлэх хувь)</i></b>	-1,3	0,5	3,6	2,5	1,4
<b><i>Азийн хөгжиж буй орнууд</i></b>	0,3	1,7	9,2	4,9	2,8
Шинээр аж үйлдвэржсэн эдийн засгууд	0,9	3,2	2,5	0,9	0,4
БНХАУ	-4,1	3,9	-9,2	-3,4	-0,5
Монгол	-6,0	-4,2	-7,2	-	-
Төв Азийн БНУлсууд	-5,5	-3,3	5,2	4,4	3,2
Зүүн Өмнөд Азийн орнууд	-2,3	-2,2	-2,0	-3,1	-2,5
Өмнөд Азийн орнууд	4,4	-1,1	-1,6	-	-
Номхон далайн орнууд					
<b>Өр ба өрийн үйлчилгээний харьцаа</b>	14,2	16	19,2	17,7	13,5

<b>Азийн хөгжиж буй орнууд</b>	-	-	-	-	-
Шинээр аж үйлдвэржсэн эдийн засгууд	6,7	9,8	-	-	-
БНХАУ	4,4	3,1	1,6	3,6	2,3
Монгол	15,7	22,2	-	-	-
Төв Азийн БНУлсууд	15,6	17,6	17,0	15,9	11,1
Зүүн Өмнөд Азийн орнууд	30,2	29,6	29,0	25,3	23,9
Өмнөд Азийн орнууд	10,7	12,2	0,6	-	-
Номхон далайн орнууд					


Зүүн Өмнөд Ази болон дэлхийн зарим бүс нутгийг хамарсан эдийн засгийн хямрал, бараа бүтээгдэхүүний дэлхийн зах зээлийн уналт, улс төрийн дотоод тогтворгүй байдал зэрэг нь манай эдийн засагт сөргөөр нөлөөлж, сүүлийн 2 жилд багагүй бэрхшээл тулгарч байлаа. Манай экспортын бүтээгдэхүүний 50-80 хувийг эзэлдэг зэс, алт, ноолуурын үнийн бууралтаас экспортын орлого 1998-2000 онд жилд дунджаар 100 гаруй сая ам доллараар, төсвийн орлого 30.0 гаруй тэрбум төгрөгөөр буурч, төсвийн зарлага санхүүжилт хүндрэх, энэ нь эргээд нийт эдийн засгийн байдал ялангуяа банк, санхүүгийн байдалд хүчтэй нөлөөлсөөр байлаа.

Энэ нь цөөн нэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэн экспортолдог эдийн засгийн бүтцийн сул талыг харуулж байгаа бөгөөд гадаад нөхцөл байдлын өөрчлөлтийг манай эдийн засаг ямар амархан мэдэрч буйг харуулсан сургамж үлдээж байна.

?????????? ?????????? ????? ?????? 1 ?? ??????? ???



1997 оноос эхлэн дэлхийн зах зээл дээр буурч байсан нэг баррель газрын түүхий тосны үнэ 1999 оны 4 дүгээр сараас хойш газар зүйн байршлаасаа хамааран ихээхэн өслөө. Энэ нь газрын тос олборлогч орнуудаас олборлолтыг бууруулах талаар явуулсан бодлого, Азийн эдийн засгийн хямралт байдал зөөлөрч, сэргэх хандлага гарсантай холбоотой байна.



1999 оны сүүлийн хагасаас Ази болон дэлхийн эдийн засаг, худалдаа сайжрах хандлагатай болж, түүхий эд, материалын эрэлт нэмэгдэж, үнэ нь өсөх хандлагатай болсон нь манай улсын эдийн засагт эерэг нөлөө үзүүлэх нөхцөлийг бүрдүүлсэн. Зэсийн дэлхийн зах зээлийн үнэ энэ онд дундажаар 1850 ам. доллар хүрэхээр төсөөлж байна. 2000 оны 1 дүгээр сарын сүүлчээр нэг тонн зэсийн үнэ 1916 ам долларт хүрч байснаа эргэж бууран 4

дүгээр сарын 11-ний байдлаар 1680 ам. доллар байна. Газрын түүхий тосны олборлолтыг нэмэгдүүлэх талаар Газрын тос олборлогч орнуудын холбооноос шийдвэр гарсны дараахнаас нэг баррель нь 30.0 ам. долларт хүрч байсан газрын тос 4 дүгээр сарын 18-ны байдлаар 25.9 ам. доллар болж буурсан байна.